



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 4/137

Есөнбулаг

Аймгийн тэргүүний хамт олон
шалгаруулж, шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, 4.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.8, 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэг, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020-2025 оны үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх чиглэлийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд манлайлан ажиллаж, шинэлэг ажлуудыг санваачлан бодит үр дүн гаргасан байгууллагуудыг аймгийн “Тэргүүний хамт олон”-оор шалгаруулан нэрсийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Дагалдах мөнгөн шагналын 7,605,000 (долоон сая зургаан зуун таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Тэргүүний хамт олноор шалгарсан байгууллагын даргыг нэг сарын үндсэн цалингаар, хамт олныг байгууллагын төсөвтөө багтаан урамшуулахыг төсвийн шууд захирагчдад зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



C:My document ZAX A-4

8200010565

02 Аймгийн Засаг даргын 2024 оны
...дугаар сарын ...-ны өдрийн ...дугаар
захирамжийн ... дүгээр хавсралт

ТЭРГҮҮНИЙ ХАМТ ОЛОН ЦЭ.А0042

1. "Говь-Алтай 80+ хөтөлбөрийг амжилттай батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж, орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлж, "Эрүүл Алтай-Эрүүл эрчүүд" урьдчилан сэргийлэх үзлэг, "Хөдөөгийн сум, багийн иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх" аяны хүрээнд явуулын үзлэг, оношилгоог үр дүнтэй зохион байгуулж амжилт гарган түүчээлэгч (Эрүүл мэндийн салбарын байгууллагууд)

2. Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, багш, ахлах ангийн сурагчдыг зөөврийн компьютероор хангаж, цахим шилжилтийг анхлан нэвтрүүлж, улсын хэмжээнд 1 дүгээр байранд орсон (Боловсролын салбарын байгууллагууд)

3. "Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд аймагт 108 сая мод тарьж ургуулах арга хэмжээ, аялал жуулчлалын аймгийн батлагдсан хөтөлбөрийг хамгийн сайн хэрэгжүүлэгч, түүчээлэгч (Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагууд)

4. Туульсын хаан Жангар соёлын биет болон биет бус өвийг уламжлуулагч, "Хос бичигтэн аймаг" аяныг санаачлан амжилттай хэрэгжүүлэгч, уламжлалт эрийн гурван наадмыг сэргээн өвлүүлэгч, "Аяганы соёл 80+" аяны амжилттай хэрэгжүүлэгч (Соёл урлагийн салбарын байгууллагууд)

ТЭРГҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД:

5. "Газар тариалан, жимс жимсгэнэ" хөтөлбөр, "Хүргэлт нэгдсэн арга хэмжээ", "Алтайн малчдын түншлэл-88" төсөл арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлэгч (Хүнс, хөдөө аж ахуйн газар)

6. Сумдын шинэчлэл хөдөөгийн хөгжил хөтөлбөр, дэд бүтэц, бүтээн байгуулалтуудын ажлуудыг амжилттай хэрэгжүүлэгч (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар)

7. Шинэ технологи, инноваци хөгжүүлэлт, Хантайшир-100 ойн арга хэмжээний Брендбүүкийг амжилттай бүтээн ажилласан (Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв УТҮГ)

8. "Хан тайшир уул"-ын аймгийн түүхт 100 жилийн ойг тохиолдуулан "Хүүхдийн баяр наадам"-ыг анх зохион байгуулж, "Засагт ханы хот айл гэр зуслан"-г амжилттай хэрэгжүүлэгч (Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар)

9. Орон нутгийн бүтээн байгуулагч (Зэвсэгт хүчний 0341 дүгээр анги)

10. Ногоон бүс, камержуулалтын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэгч (Цагдаагийн газар)


11. Гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургалт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэн, Уулын болон усны сургалтын төвийг барьж ашиглалтад оруулж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэгч (Онцгой байдлын газар)

12. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх "Эрүүл Монгол" аяны хүрээнд "Цаг гаргая" "Эерэг хандлага-эерэг нийгэм" зэрэг арга хэмжээний амжилттай хэрэгжүүлэгч (Биеийн тамир спортын газар)

13. Хил хамгаалах, туслах хүчний үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж буй (Хилийн цэргийн 0214 дүгээр анги) тус тус шалгарсан болно.

__оОо__

Аймгийн Засаг даргын *2014* оны
02 дугаар сарын *08* -ны өдрийн *167* дугаар
захирамжийн *02* дугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Нэгжийн үнэ /төгрөгөөр/	Байгууллагын тоо	Нийт /төгрөгөөр/
1.	Өргөмжлөл	75,000	13	975,000
2.	Дагалдах мөнгөн шагнал	500,000	13	6,500,000
3.	Батламж	10,000	13	130,000
4.	Нийт мөнгөн дүн	585,000	13	7,605,000

__оОо__